



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/33

Жаргалтхаан

Зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 03 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх зорилгоор “Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн”-ийг 2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр зохион байгуулсугай.

2.Сумын төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Отгонбаяр – Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: С.Мөнхдэлгэр – Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Д.Чинбат – Ерөнхий боловсролын сургуулийн

захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Н.Түвшинжаргал – Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Б.Хүрэлбаатар – Цагдаагийн тасгийн дарга

Д.Өнөржаргал – Цэцэрлэгийн эрхлэгч

Ж.Ариунгэрэл – Соёлын төвийн дарга

Л.Цэнгэл – ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн

(Зөвшилцсөнөөр)

Б.Амгаланбаяр – Нийтийн биеийн тамирын арга зүйч

Э.Жамсранжав - Эрэн хайх,аврах бүлгийн дарга

3.Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг удирдамж, төсөв, төлөвлөгөөг боловсруулан батлуулж, зөвлөгөөнийг чанартай зохион байгуулахыг ажлын хэсэг (Н.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА



С.ГАНБАТ